



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/247

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Буянт сумын Нарийн гол багт “Эвлэл” ХХК-ийн барьж гүйцэтгэсэн мал угаалгын ваннын ажлыг хүлээж авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Д.Батцэнгэл - Мал эмнэлгийн газрын дарга
Гишүүд: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан мэргэжилтэн
Б.Түвшинсайхан - Буянт сумын Засаг дарга
Ч.Идэрсайхан - Буянт сумын Засаг даргын орлогч
Э.Мягмар - Буянт сумын Нарийн гол багийн Засаг дарга
У.Батзаяа - “Эвлэл” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Мал угаалгын ванныг хүлээн авахдаа холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга (Д.Батцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

8400 01 1249
Zah A/247 Kh